



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 43

Мандалговь


**ГХөрөнгө балансаас баланст шилжүүлэх тухай**

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 113,262,486 /нэг зуун арван гурван сая хоёр зуун жаран хоёр мянга дөрвөн зуун наян зургаа/ төгрөгийн анхны өртөгтэй 71,666,667 /далан нэгэн сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий Гэгээрлийн төвийн барилгыг Эрүүл мэндийн газарт балансаас баланст шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг зохих журмын дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг Эрүүл мэндийн газрын дарга Ц.Энхсайхан, данс бүртгэлээс хасахыг Нэгдсэн эмнэлэгийн дарга Х.Жаргал нарт тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА  С.СУХБААТАР

